



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 11320

Арвайхээр сум

### Онцгой байдлын ажиллагааны удирдлагын төвийг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.8 дахь заалт, Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 06 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын Шадар сайдын ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хамтран 2023 оны 06 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд “Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдож онц байдал тогтоосон үеийн төрийн байгууллагын харилцан ажиллагаа” сэдэвт стратегийн команд штабын сургуулилтад аймгийн Онцгой комисс, Гамшигаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн дарга, сумын Засаг дарга нарыг бэлтгэл ажлыг сайтар хангуулж оролцуулсугай.

2.Стратегийн команд штабын сургуульд оролцох Онцгой байдлын ажиллагааны удирдлагын төвийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, гүйцэтгэх үүргийг 2 дугаар, Онцгой байдлын ажиллагааны удирдлагын төвийн бүтцийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Стратегийн команд штабын сургуульд оролцох бэлтгэл ажлыг өндөр түвшинд зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн), Онцгой байдлын газрын дарга (дэд хурандаа Д.Одонбаяр)-т, хариуцлагатай бэлэн байдлыг хангаж оролцохыг аймгийн Онцгой комиссын гишүүд, гамшигаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн анги сумдын Засаг дарга болон төрийн байгууллагын удирдлага, алба хаагчдад тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0614

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар  
сарын .... -ны өдрийн .... дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт

**ОНЦГОЙ БАЙДЛЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН  
ТӨВИЙН АЖИЛЛАХ БҮРЭЛДЭХҮҮН**

№	Овог, нэр	Албан тушаал	Нэгжийн нэр
<b>Нэг. Ослын үеийн шуурхай штабын удирдлага</b>			
1.1	И.Доржсүрэн	Аймгийн Засаг даргын орлогч	Ослын үеийн Шуурхай штабын дарга
1.2	Д.Одонбаяр	Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа	Ослын үеийн Шуурхай штабын дарга, орлогч дарга
<b>Хоёр. Холбогч офицер</b>			
2.1	М.Дэлгэрсайхан	Цэргийн штабын дарга, хурандаа	Холбогч офицер
2.2	Т.Батсайхан	Цэргийн штабын дайчилгааны офицер, хошууч	
2.3	Б.Балжинням	Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн гал унтраах албаны дарга, хошууч	
2.4	А.Чулуунбямба	Онцгой байдлын газрын холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн, дэслэгч	
<b>Гурав. Олон нийтийн мэдээллийн ажилтан</b>			
3.1	Ш.Мөнхцэцэг	Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээллийн ажилтан	Олон нийтийн мэдээллийн ажилтан
3.2	Б.Энхмаа	Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээллийн ажилтан	
3.3	Б.Алтанцацрал	Цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх, чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч	
3.4	Г.Алтанцэцэг	Онцгой байдлын газрын ангиллын сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, дэслэгч	
<b>Дөрөв. Аюулгүй байдлын ажилтан</b>			
4.1	Ж.Уламбаяр	Тагнуулын ерөнхий газрын Өвөрхангай аймаг дахь Тагнуулын хэлтсийн дарга, хурандаа	Аюулгүй ажилтан
4.2	Г.Чимэддагва	Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа	
<b>Тав. Ажиллагааны баг</b>			
5.1	Ж.Хаш-Эрдэнэ	Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, хошууч	Ажиллагааны багийн ахлагч
5.2	Д.Мөнхням	Гал түймэр унтраах, аврах 12 дугаар ангийн захирагч, хошууч	Эрэн хайх, аврах ажиллагаа, гал түймэр унтраах хэсэг
5.3	Т.Эрдэнэ-Очир	Эрэн хайх, аврах салбарын захирагч, дэслэгч	
5.4	Б.Дэмбэрэлсайхан	ЭБЦС, ТӨХК-ийн Өвөрхангай аймаг дахь салбарын дарга	Дэд бүтэц хариуцсан хэсэг



5.5	Д.Лхам-Оролмаа	“ӨВ АЗЗА” ТӨХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ	Эмнэлгийн тусlamж үйлчилгээний хэсэг
5.6	Ц.Хоролсурэн	Онги-Ус суваг ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ	
5.7	Г.Дашжанцан	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн захирал	
5.8	А.Нямдаваа	Мал эмнэлгийн газрын дарга	
5.9	Б.Сүхбаатар	Зоонозын өвчин судлалын төвийн дарга	
5.10	М.Золзаяа	Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга	Хэв журам сахиулах, замын хөдөлгөөн зохицуулах хэсэг
5.11	Х.Батпүрэв	Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн хошууч	
5.12	Т.Алтан-Эрдэнэ	Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч	
5.13	Б.Ганбат	Арвайхээр сумын Засаг дарга	Арвайхээр сумын ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, сайн дурын хэсэг
5.14	С.Ганчимэг	Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газрын дарга	
5.15	Б.Балжинням	Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад	
5.16	О.Ууганбаяр	Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн штабын дарга, дэд хурандаа	Ажиллагааны зургийн хэсэг
5.17	П.Мөнхдалай	Онцгой байдлын газрын Аврах бүлгийн дарга, аврах ажиллагааны зааварлагч, ахлах дэслэгч	
5.18	Ч.Адъяа	Цэргийн штабын орон нутгийн хамгаалалт, сургалт бэлтгэлийн офицер, дэд хурандаа	Ажиллагааны багийн нарийн бичгийн дарга
5.19	Сумдын Засаг дарга, Тамгын газрын дарга нар		Сумдын ерөнхий зориулалтын мэргэжлийн анти

#### Зургаа. Төлөвлөлтийн баг

6.1	Ч.Гүнсэнхорол	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	Төлөвлөлтийн багийн ахлагч
6.1	Ч.Чанцалдиймаа	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга	Нэхцэл байдлын үнэлэх, мэдээлэл цуглуулрах хэсэг
6.2	Б.Цэдмаа	Улсын бүртгэлийн хэлтсийн дарга	
6.3	Ч.Хүрэлбаатар	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, хурандаа	Хүн хүч, техник хэрэгслийн тооцоо, судалгааны хэсэг
6.4	д/х Б.Батсайхан	Онцгой байдлын газрын Хүний нөөц, бие бүрэлдэхүүний сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа	
6.5	Н.Чимэддорж-Ойдов	Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга	
6.6	Ц.Дашзэвэг	Цагдаагийн газрын дэд бөгөөд эрүүгийн тасгийн дарга, цагдаагийн хошууч	

6.7	Г.Баясгалан	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга	Хариу арга хэмжээний төлөвлөлтийн хэсэг
6.8	Д.Шивааннурдэв	Эрүүл мэндийн газрын дарга	
6.9	А.Мөнхбат	Нисэх буудлын дарга	
6.10	Г.Ганбаатар	Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, хошууч	Төлөвлөлтийн багийн нарийн бичгийн дарга
Долоо. Нөөц хангалтын баг			
7.1	Ц.Ганболд	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга	Нөөц хангалтын багийн ахлагч
7.2	Т.Ариунболд	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга	Барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, хүн, хүч, эм, эмнэлгийн хэрэгслийн хангалтын хэсэг
7.3	Н.Гүрбадам	Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн захирагч, хурандаа	
7.4	Б.Галбат	Зэвсэгт хүчний 113 дугаар салбарын захирагч, хошууч	
7.5	Д.Амартувшин	Авто тээврийн төвийн дарга	
7.6	Ж.Ганбаатар	Онцгой байдлын газрын хөдөлмөр, хамгаалал, аюулгүй ажиллагаа, техник хэрэгсэл хариуцсан мэргэжилтэн, хошууч	
7.7	Ю.Ичинноров	Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга	
7.7	М.Жамъяншарав	Мэдээлэл холбоо, сүлжээ ТӨХК-ийн Өвөрхангай аймаг дахь газрын дарга	Харилцаа холбоо, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, хүнсний хангамжийн үйлчилгээний хэсэг
7.8	Б.Энхцогт	Улаан загалмайн хорооны дарга	
7.9	М.Нямсүрэн	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	
7.10	С.Цэдэнбалжир	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга	
7.11	a/x Б.Гаваадамба	Онцгой байдлын газрын эмч, сэтгэл зүйч, ахмад	Нөөц хангалтын багийн нарийн бичгийн дарга
Найм. Санхүү, захираганы баг			
8.1	Ц.Идэрсайхан	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга	Санхүү, захираганы багийн ахлагч
8.2	О.Цэрэнчимэд	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч	Худалдан авалт, Зардал хариуцсан хэсэг
8.3	Т.Эрдэнэсүрэн	Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны ахлах мэргэжилтэн	
8.4	Б.Сэргэлэнбаатар	Гамшигийн эрсдэлийн удирдлага, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, ахлах дэслэгч	Цагийн буртгэл хариуцсан офицер
8.5	А.Отгонцэцэг	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга	Захирамж, бичиг баримт хариуцсан хэсэг
8.5	Г.Нацагханд	Цагдаагийн газрын Нягтлан бодогч, цагдаагийн дэслэгч	

8.6	Б.Валя	Эрүүл мэндийн газрын Нягтлан бодогч	
8.7	Ц.Алдаржав	Онцгой байдлын газрын ахлах Нягтлан бодогч, хошууч	Санхүү, захиргааны багийн нарийн бичгийн дарга

-оOo-

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 10 -ны өдрийн 10 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

## ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ САЛБАР БАГУУДЫН ҮНДСЭН ҮҮРЭГ

Ослын үеийн шуурхай штабын даргын үүрэг:

- Штабын үйл ажиллагааг удирдлагаар хангах.
- Үйл явдлын төрлөөс хамаарч баг, бүрэлдэхүүнийг томилох.
- Ослын үеийн аюулгүй байдлыг хангах.
- Ослын үеийн удирдлагын байрыг байгуулах.
- Нөхцөл байдлын үнэлгээ хийх,
- Нэн тэргүүний шаардлагатай арга хэмжээг эхлүүлэх.
- Ослын үеийн дагаж мөрдөх зорилго, стратегийг тодорхойлох.
- Ослын үеийн ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх.
- Удирдлагын штаб, ажиллагааны багийн үйл ажиллагааг зохицуулах.
- Нэмэлт хүч хэрэгсэл эсвэл хүч хэрэгслийг буулгах хүсэлтийг батлах.
- Хэвлэл, мэдээллийнхэнд өгөх мэдээллийг хянах.
- Ажиллагаанд оруулах шийдвэрийг гаргах.
- Ослын дараах арга хэмжээний тайлангийн боловсруулалтыг хангах.
- Хэвлэл, мэдээллийнхэнд мэдээлэл өгөх

Холбогч офицерийн үүрэг:

- Бусад байгууллагуудтай холбоо тогтоох, харилцан мэдээлэл солилцох ажилтан.
- Тусалж байгаа болон хамтран ажиллагч байгууллагуудын төлөөлөгчдийн нэр хаяг, утсыг тодотгох.
- Байгууллагуудын төлөөлөгчдийг хооронд нь холбоход дэмжлэг үзүүлэх, хяналт тавих.
- Байгууллага хооронд үүссэн болон үүсэж болзошгүй асуудлыг олж тогтоох зорилгоор ослын ажиллагаанд хяналт тавих.
- Байгууллагуудын хүч хэрэгслийн хязгаарлалт, хүчин чадавхыг багтаасан одоо байгаа хүч хэрэгслийн талаарх мэдээллийг өгөх.
- Байгууллага тус бүрийн ажиллагаанд оролцох талаарх мэдээлэл, шаардлагыг хүргүүлэх.

Олон нийтийн мэдээллийн ажилтны үүрэг:

- Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу мэдээллийг олон нийтэд мэдээлэх.
- Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр цацах үнэн зөв, хүртээмжтэй, цаг үеэ олсон мэдээллийг бэлтгэх.
- Удирдлагаас осолтой холбоотой гарах бүх мэдээллийг батлуулах.
- Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээг давтамжтайгаар хүргэх.
- Шаардлагатай үед мэдээ явуулах, ярилцлага, газар орон дээрх сурвалжилгыг зохион байгуулах.
- Осолтой холбоотой мэдээлэл, тойм, нэвтрүүлгийг хариуцах.
- Осолтой холбоотой мэдээллийг ослын хор уршигийг арилгах бие бүрэлдэхүүнд зориулж бэлтгэх.

## Аюулгүй байдлын ажилтны үүрэг:

- Аюултай нөхцөл байдлыг олж тогтоох, аюулыг бууруулах.
- Аюулгүй ажиллагааны зааварчилгааг танилцуулсан эсэхийг хянах.
- Ажиллагааны үеэр аюултай ажиллагааг зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх.
- Ослын үеийн ажиллагааны төлөвлөгөөнд аюулгүй байдлыг тусгасан эсэхийг шалгах.
- Ослын голомтод ослын нөхцөл байдлыг тогтоох эхний үнэлгээг эхлүүлэх.
- Эрүүл мэндийн төлөвлөгөөг хянах, батлах.

## Ажиллагааны баг:

- Төлөвлөлт, Санхүү, ар тал, хангалтын хэсгүүдийн үйл ажиллагааг тодорхойлж уялдаа холбоогоор хангах.
- Эрэн хайх, аврах хор уршгийг үр дүнтэй явуулах зорилго дээр үндэслэн тактикийг тодорхойлох, удирдлагын штабт танилцуулах;
- Хүн хүч хэрэгслийг хуваарилах санал гаргаж шийдвэрлүүлэх;
- Хэсэг, бүлгийн үйл ажиллагааг тодорхойлох;
- Тактикийн ажиллагааны аюулгүй байдлыг хангах;
- Тактикийн ажиллагааг удирдах;
- Шаардагдах нэмэлт хүч хэрэгслийг хүсэх/захиалах;
- Үйл ажиллагааны төлөвлөгөөний ажиллагаатай холбоотой хэсгийг боловсруулахад туслах;
- Гамшгийн үеийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй холбоотой хэсгийн хэрэгжилтийг хянах.
- Тактикийн ажиллагааг дэмжих нэмэлт хүч хэрэгслийг хүсэх;
- Хүч хэрэгслийг даалгавраас татах;
- Удирдлагын штабтай холбоотой ажиллах, ажиллагаанд оролцогч бие бүрэлдэхүүнийг удирдлагаар хангах;
- Шаардлагатай алба, мэргэжлийн ангийг татан оролцуулах талаар удирдлагад санал гаргах, оролцуулах, удирдлагаар хангах, хяналт тавих;
- Ажиллагааны асуудлаар бүх төрлийн мэдээлэл өгөх;
- Бусад

## Төлөвлөлтийн баг:

- Гамшигтай холбоотой ажиллагааны талаарх мэдээллийг цуглуулах
- Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага болон Улсын болон орон нутгийн гамшигаас хамгаалах алба, Улсын Онцгой комисстий ажиллах төлөвлөлтийг төлөвлөгөөнд нэгтгэх.
- Гамшгийн үеийн ажлын төлөвлөгөөний бэлтгэлийг хангуулах.
- Ажиллагааны хэсгийн даргад гамшгийн үед ажиллах ажиллагааны төлөвлөгөө гаргахад шаардагдах мэдээллийг бэлтгэн өгөх.
- Төлөвлөлтийн хурлуудыг зохион байгуулах
- Бүх төрлийн төлөвлөгөөнд тодотгол хийх, баталгаажуулах;
- Шинээр төлөвлөлтийг боловсруулах;
- Гамшгийн нөхцөл байдлын мэдээг нэгтгэх, удирдлагын штабт танилцуулах.
- Гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд шаардагдах тусгай хүч хэрэгслийн хэрэгцээг тодорхойлох;
- Нөөц стратеги, гэнэтийн тохиолдлын төлөвлөгөө гаргахад шаардагдах мэдээллийг цуглуулах;
- Гамшгийн нөхцөл байдалд орсон онцгой өөрчлөлтүүдийн талаар мэдээлэх;
- Томилгоот бүрэлдэхүүний нөхөн хангалтыг хийх, хүний нөөцийн судалгаа хийх

- Харилцаа холбоо, эмнэлэг, замын хөдөлгөөний талаар төлөвлөгөө бэлтгэх;
- Төлөвлөлтийн асуудлаар бүх төрлийн мэдээлэл өгөх;
- Бусад

**Нөөц хангалтын баг:**

- Гамшгийн үед шаардлагатай нөөцийг тодорхойлох;
- Бүх төрлийн нөөцийг бүрдүүлэх;
- Олон улсын болон бусад байгууллагын өгсөн тусlamжийн барааг хуваарилах, хүргүүлэх;
- Хүмүүнлэгийн тусlamжийг зохион байгуулах;
- Нөөцөөс бараа материал шаардлагатай зүйлсийг гаргах;
- Шаардлагатай нөөцийг бусад хэсэгтэй хамтран шийдвэрлэх;
- Нөөцийн асуудлаар бүх төрлийн мэдээлэл өгөх;
- Удирдлагын штабын байр зүйн зургийг бэлтгэх, хөтлөх;
- Цаг агаарын болон бусад нөхцөл байдлын мэдээллээр хангах;
- Барилга байгууламжийн план зураг болон бусад төрлийн байр зүйн зургаар хангах ажлыг зохион байгуулах;
- Шаардлагатай тохиолдолд мэдээлэл цуглуулах тусгайлсан системийг бий болгох; (жишээлбэл цаг агаарын талаар)

**Санхүү, захиргааны баг:**

- Шаардлагатай санхүү, зардлын дүгнэлт шинжилгээ бүхий мэдээллээр хангах;
- Хариуцсан байгууллагуудын мэдээллээс холбогдох мэдээллийг авах;
- Санхүүгийн хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг бэлтгэх, шаардлагатай хэрэгслээр хангах;
- Бүх хэсэгт шаардлагатай санхүүгийн дэмжлэгийг үзүүлэх;
- Санхүүгийн асуудлаар бүх төрлийн мэдээлэл өгөх;

-оОо-

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 10:00 дугаар захирамжийн 3 дугаар хавсралт



## ОНЦГОЙ БАЙДЛЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨВИЙН БУТЭЦ

